

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**

Өдөр +11  
Шөнө +2

**УЛС ТӨР**

ҮНДСЭН ХУУЛИАР ОЛГОГДСОН ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ЭРХ БОДИТОЙ ХЭРЭГЖИХ НЬ

II нүүрт

**SPEAK OUT**

ИРГЭД ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД СӨРӨГ ХҮЧИНГ ДЭМЖИНЭ

V нүүрт

Дугаарын **60** мөр

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

Голсон юм  
голд гэдэг  
шүү дээ

## ХҮҮХДЭЭРЭЭ ЭЭЖ БОЛСОН НЬ ОХИДЫН БУРУУ БИШ, ХАРИН...

Э.ТУУЛ

Аливаа өвчин үүсэх өөр, өөрийн шалтгаантай, мөн түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлс нь ч янз бүр гэдгийг эмч, мэргэжилтнүүд хэлдэг. Гэтэл сүүлийн жилүүдэд монголчуудын дунд янз бүрийн өвчин газар авч, зарим нь бүр хүндэрч, харийн улсыг зориход хүргээд байгаа. Ялангуяа балчир үрсийн дунд цаг агаар, хоол ундны хэрэглээ зэргээс үүдэлтэй огцом өвдөлт үүсдэг байсан бол сүүлийн жилүүдэд суурь өвчтэй хүүхдүүд олширсон гэдгийг тэд хэлж байна. Тодруулбал, амьсгалын замын болон цус багадагт зэрэг өвчин хүүхдүүдийн дунд зонхилон тохиолдох өвчлөлийн дийлэнх хувийг эзэлж эхэлсэн байна.

Үргэлжлэл нь III нүүрт



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

## ТАВАНТОЛГОЙГ ХЯТАДТАЙ ХОЛБОХ ТӨМӨР ЗАМ ХЯМРАЛЫГ ГЭТЛЭХ ГАРЦ УУ

Б.ДАВААХҮҮ

УИХ-ын намрын чуулганы тов гарчээ. Засгийн газар энэ удаагийн чуулганы хуралдаанд эдийн засгаа аврах цогц төлөвлөгөөг танилцуулах учиртай. Чуулган эхлэх хүртэл уг төлөвлөгөөнд юу тусгагдсан нь таамаг төдий хэдий ч, Тавантолгойн ордыг хөдөлгөх асуудал аль хэдийн дэлхий нийтэд нээлттэй хөзөр болсон гэж хэлэхэд хэвийдэхгүй болов уу. Учир нь сүүлийн үед МАН-ын Засгийн газар урд хөршөө түшин Тавантолгойн ордоо хөдөлгөх нь гэх "бор шувуу" эрчимжсэн. Нэг талаар, энэ нь УИХ-ын ээлжит бус чуулганд хэд хэдэн гишүүн тус ордыг эргэлтэд оруулах боломж хийгээд нүүрсний ханшийн өсөлтийг дурьдаж байсантай холбоотой ч байж мэдэх. Ямартай ч УИХ дахь 65 кноп шийдвэрээ гаргах бөгөөд хэрхэн шийдэх нь эдүгээ хүлээлт төдий байгаа юм. Харин чуулганаас урьтаж, хоёр хөршийн болоод дэлхийн хэвлэлд Тавантолгойн ордын талаар хэрхэн дурьдагдсаныг "Монгол дэлхийн хэвлэлд" булангаараа сонирхуулахаар бэлдлээ.

Тавантолгойн ордыг Хятадтай бүрэн холбоход дахиад 800 сая ам.доллар шаардлагатай

БНХАУ-ын тэргүүдэд Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкнаас Монгол Улс эзэл хүссэн гэх мэдээлэл цацагдлаа.

Үргэлжлэл нь III нүүрт

Үргэлжлэлийг VII нүүрээс

## "ШИНЭ ТӨГӨЛ"

цэцэрлэгт хүүхэд багачуудыг урьж байна



Олон Улсын стандартад нийцсэн "Шинэ төгөл" цэцэрлэг "Маршал таун" хотонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. "Шинэ төгөл" цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

**АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.**



Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS

4-5 настай хүүхэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх-тос багатай, шарж хуураагүй байдагаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.



**ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО**  
**Холбоо барих утас: 99094864**



Энэтхэгийн Элчин Сайдын Яам  
Улаанбаатар

## МАНАТМА ГАНДИЙН ӨДӨР

Махатма Гандийн Төрсөн Өдрийн Баярыг Олон Улсын Хүч Үл Хэрэглэх Өдөр хэмээн 2016-10-2 (Ням гараг)-ны өглөөний 10:00-10:45 цагт Улаанбаатар хотын Хан-Уул Дүүргийн Махатма Гандийн гудамж дахь Махатма Гандийн хөшөөнд цэцэг өргөн хүндэтгэх арга хэмжээг Улаанбаатар дахь Энэтхэгийн Элчин Сайдын Яам зохион байгуулах гэж байна.

*Бүгдийг тин сэтгэлээсээ урьж байна.*

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2265.00	2283.00	ФУНТ	2886.00
ЕВРО	2520.00	2591.00	РУБЛЬ	34.20
ИЕН	22.33	22.97	ЮАНЬ	338.30
			Авах	Зарах
			АМ.ДОЛЛАР	2267.00
			ЕВРО	2521.00
			ИЕН	22.27
			Зарах	2282.00
			ФУНТ	2911.00
			РУБЛЬ	34.42
			ЮАНЬ	338.00
				342.60

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

## УЛС ТӨР

# ҮНДСЭН ХУУЛИАР ОЛГОГДСОН ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ЭРХ БОДИТОЙ ХЭРЭГЖИХ НЬ

УИХ-ын чуулганаар болон ИТХ-ын хуралдаанаар асуудал хэлэлцүүлэх саналыг тодорхой тооны иргэд хамтран санаачлах эрхтэй байх аж. Ард нийтийн санал асуулгыг тодорхой тооны иргэд хамтран санаачлах эрхтэй байх бол орон нутгийн санал асуулгыг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оршин суугч тодорхой тооны иргэд хамтран санаачлах эрхтэй байхаар хуулийн төсөлд тусгажээ...



хэлэлцүүлэг хийлээ. Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд болсон уг хэлэлцүүлэгт хуульч, судлаачид, багш нар, СЕХ-ны мэргэжилтнүүд төрийн зарим байгууллагын ажилтнууд оролцсон юм.

Хэлэлцүүлгийг нээж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хүний эрх, хуулийн бодлогын зөвлөх Ч.Өнөрбаяр хэлэхдээ “Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр боловсруулсан Иргэдийн улс төрийн эрхийн тухай хуулийн төслийг Үндсэн хуулийн эрх зүйгээр мэргэшсэн, энэ чиглэлээр судалгаа хийдэг хүмүүсээр хэлэлцүүлэх нь зүйтэй юм гэж үзлээ. Хуулийн төслийн ажлын хэсгийг энэ оны хоёрдугаар сард байгуулж ажилдуулсан. Швейцарийн талаас ирүүлсэн санал дээр мөн ажлын хэсгийнхэн ажилласан” гэдгийг дуулгасан юм.

Хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн хуульч А.Алтанзул, Х.Номингэрэл нар хийж, хуулийн төслийн талаарх

Үндсэн хуулийн судлаачдын хууль зүйн дүгнэлтийг доктор Ч.Энхбаатар танилцууллаа. Иргэдийн улс төрийн эрхийн тухай хууль нь иргэн төрийн үйл хэрэгт шууд оролцох улс төрийн эрхийг иргэдийн санаачилгаар хэрэгжүүлэх үндэслэл, иргэд хуулийн төслийг хууль санаачлагчид уламжлах зорилгыг агуулсан байгаа аж. Түүнчлэн ард нийтийн болон орон нутгийн санал асуулга явуулах зарчим, журам, санал асуулгаар шийдвэрлэх асуудлын хүрээг тодорхойлох, санал асуулгыг бэлтгэх, зохион байгуулж явуулах, санал асуулгын үр дүнг хэлбэржүүлэхтэй холбоотой асуудлыг зохицуулах зэрэг зорилгыг агуулсан байна.

Хуулиар иргэдийн санаачилгаар УИХ-ын чуулганаар болон ИТХ-ын хуралдаанаар асуудал хэлэлцүүлэхээр санаачлах аж. Эсвэл ард нийтийн болон орон нутгийн санал асуулга явуулах, санал асуулгын дүнг шийдвэрлэгдсэнд тооцогтой холбогдсон харилцааг зохицуулах юм байна. УИХ-

ын чуулганаар болон ИТХ-ын хуралдаанаар асуудал хэлэлцүүлэх саналыг тодорхой тооны иргэд хамтран санаачлах эрхтэй байх аж. Ард нийтийн санал асуулгыг тодорхой тооны иргэд хамтран санаачлах эрхтэй байх бол орон нутгийн санал асуулгыг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оршин суугч тодорхой тооны иргэд хамтран санаачлах эрхтэй байхаар хуулийн төсөлд тусгажээ.

Энхүү хууль батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын бүх ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх механизм бүрдэх гэнэ. Түүнчлэн Үндсэн хуулиар олгогдсон иргэний улс төрийн эрх бодитой хэрэгжинэ хэмээн хууль санаачлагчид үзжээ.

## Татвар төлөгчдөд дарамт үзүүлдэг байдлыг шийдвэрлэнэ гэв

Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт Монголын бизнесийн зөвлөлийн төлөөллийг өчигдөр хүлээн авч уулзлаа. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын захирамжаар хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас дарамт шахалт үзүүлсэн, үндэслэлгүйгээр мөрдөн шалтгаан асуудал байгаа эсэхийг судлах ажлын хэсэг байгуулсан. Энэ хүрээнд С.Бямбацогт сайд Монголын бизнесийн зөвлөлийнхний саналыг сонссон юм. Уулзалтад оролцсон “Эрдэнэс Монгол” компанийн захирал Б.Бямбасайхан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтайгаа уулзаж, нөхцөл байдлыг бодитоор харж байгаад баяртай байгаагаа хэлсэн юм. Тэрбээр Хууль эрхзүйн тогтворгүй байдал хөрөнгө оруулагчдад сөргөөр нөлөөлж байгааг

хэлсэн. Сүүлийн үед гадаад, дотоодын баялаг бүтээгчдийг дэмжих чиглэлээр хийж байгаа ажлуудыг хөрөнгө оруулагчдад дуулахаад Монголын бизнесийн зөвлөл тодорхой үүрэгтэй оролцоно гэдгээ хэлж байв. Уулзалтад оролцогчид Монголын бизнесийн зөвлөлийн нэгдсэн санал дүгнэлтийг гаргаж, Хууль зүй дотоод хэргийн сайд С.Бямбацогтоор ахлуулсан ажлын хэсэгт албан бичгээр уламжлахаар боллоо. Харин С.Бямбацогт сайд хэлэхдээ “Төрийн байгууллагаас татвар төлөгчдөд хууль бус, үндэслэлгүйгээр дарамт шахалт үзүүлдэг байдлыг судалж, шийдвэрлэнэ. Цаашдаа бизнесийн эрх зүйн орчныг сайжруулахад ямар ажил хийх вэ гэдэгт санал бодлоо солилцох зорилгоор тогтмол уялдаа холбоотой ажиллана” гэдгийг уулзалтын үеэр онцолсон юм.

## Хөрөнгө оруулах Японы компаниудад зөв ойлголт өгөхийг хүслээ

Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэг Японы Ардын дипломатын нийгэмлэг (FEC)-ийн дэд дарга, Япон-Монголын соёл, эдийн засгийн харилцааны асуудал эрхэлсэн хэрооны дарга Н.Ито тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Айлчлалын багийн ахлагч ноён Н.Ито энэ оны зургадугаар сард хүчин төгөлдөр болсон Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд аж ахуй нэгж, байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагаа чухал гэдгийг онцлон, төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Монгол Улстай хамтран ажиллах сонирхолтой олон хүн ирснийг дурдав. Дэд сайд Б.Батцэцэг Японы Ардын дипломатын нийгэмлэгийн төлөөлөгчидтэй уулзаж байгаадаа баяртай байгаагаа илэрхийлж, тэдний энэхүү

айлчлал Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилын Япон Улсад хийж буй айлчлалтай цаг хугацааны хувьд давхцаж буйг тэмдэглэлээ. Түүнчлэн хоёр улсын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх үйлсэд тус нийгэмлэг томоохон үүрэг гүйцэтгэж ирсэн явдалд талархал илэрхийлсэн юм. Түүнчлэн Дэд сайд Б.Батцэцэг Монгол, Японы Стратегийн түншлэл амжилттай хөгжиж байгаад сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж, улс төрийн харилцаа өндөр төвшинд хүрч, итгэлцэл гэгдгийг хүчээр буйг цохон тэмдэглэв. Мөн Монголд хөрөнгө оруулах сонирхолтой Японы компаниудад мэдээлэл түгээх, Монголын талаар зөв ойлголт өгөхөд цаашид ч дэмжлэг үзүүлж ажиллахыг тус нийгэмлэгийн төлөөлөгчдөөс хүсэв.

### Ж.МЯГМАР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтарсан “Иргэдийн оролцоо” төслийн хүрээнд Иргэдийн улс төрийн эрхийн тухай хуулийн төслөөр

**МОНГОЛЫН МЭДЭЭ**  
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510  
Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн: Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцт эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.



## М.Билэгт гишүүн хувцаслах соёлд суралцаад жигтэйхэн

### Ж.ӨӨДЛӨН

Олимпын аварга Н.Түвшинбаяртай өрсөлдөж ялалт байгуулсан “Ачлал”-ын босс М.Билэгтийн хувьд эрэн мяраан хувцас өмсөх дуртай нэгэн. Гэтэл түүний хувцаслалт сүүлийн

өдрүүдэд нэлээд шүүмжлэл хүлээгээд байгаа. Тухайлбал, “Эрэн мяраан цаастай хямд чихрийн цуглуулгыг хэн худалдаж авах нь ойлгомжтой шүү дээ” гэж хүртэл шүүмжилж буй. Тэгвэл тэрбээр стилист, хувцасны соёлоороо удаа дараа “онигоо” болж байгаагаасаа ичсэн үү юутай ч сүүлийн өдрүүдэд хувцаслах соёлын талаар судалж эхэлжээ. Тэрбээр өөрийн албан ёсны фэйсбүүктээ “Уламжлалт ажил хэрэгч, албан ёсны, ёслолын, албан бус ажил хэрэгч хувцаслалт зэрэг зөвлөмжүүдийг хуваалцан унших болов. Үүнийг нь харсан цахим найзууд нь “ашгүй дээ ийм зүйл унш, ёстой зөв зүйл судалж байгаа юм байна” гэх зэргээр дэмжсээр байна. Тиймээс эрэн, мяраан “танхай” маягийн хувцаслалтад дуртай эрхэм гишүүн тун удахгүй парламент хувцаслалтад суралцах бололтой.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төслийг эхлүүлээ

Монгол Улсын Засгийн газар, ХЗДХЯ, Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сан хамтран зохион байгуулж буй “Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн нээлт өчигдөр Туушин Вэстэрн зочид буудлын “Соёмбо” танхимд боллоо. Тус төслийн нээлтэд Хууль зүй дотоод хэргийн сайд С.Бямбацогт, НҮБ-ын Хүн амын сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Наоми Китахара нар үг хэлж, төслийн баримт бичгэнт гарын үсэг зурлаа. Энэ үеэр Хууль зүй, Дотоод хэргийн сайд С.Бямбацогт “МУ-ын Засгийн газар “Тэр бүлийн

хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн төслийг УИХ-д яаралтай өргөн барьж, аравдугаар сарын 03-нд болох намрын ээлжит чуулганы эхэнд хэлэлцүүлэн багтах болсон” гэдгийг онцлон хэллээ. 2015 онд эдийн засаг нийгэм, соёлын эрхийн хорооны хийсэн судалгаанаас үзэхэд жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл түгээмэл байгаа юм байна. Жендэрт суурилсан хүчирхийлэлийн өнөөгийн нөхцөл байдал, бичгэнт гарын үсэг зурлаа. Энэ үеэр Хууль зүй, Дотоод хэргийн сайд С.Бямбацогт “МУ-ын Засгийн газар “Тэр бүлийн

хүчирхийлэлийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, шийдвэр гаргагчдад ухуулга, нөлөөлөл үйл ажиллагаа хийх Хүчирхийлэлд өртөгсдөд чиглэсэн үйл ажиллагааны механизмыг боловсронгуй болгон өргөжүүлэх гэх мэт арга хэмжээг авч хэрэгжүүлэх аж. 2030 он гэхэд охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийн бүх хэлбэрийг устгаж, жендэрийн тэгш байдлыг хангах тав дахь зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө ХЗДХЯ, НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлаг ийнхүү хамтран ажиллахаар боллоо.

## Нэр дэвшигчид үнэмлэхээ гардав

Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн санал авах үйл ажиллагаа ирэх аравдугаар сарын 19-ний лхагва гарагт Улаанбаатарын цагаар 07:00-22:00 цагийн хооронд явагдана. Орон нутгийн сонгуулиар 21 аймгийн 1613 баг, нийслэлийн есөн дүүргийн 152 хорооноос нийт 7282 төлөөлөгч сонгогдох юм. Нийт 7282 мандатын төлөө 15212 нэр дэвшигч бүртгүүлснээс улс төрийн нам, эвслээс 14489, бие даагч 723 нэр дэвшигч тус тус байна. Энэ удаагийн орон нутгийн сонгуульд нийт 10 нам эвслээс сонгуульд өрсөлдөх



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

хүсэлтэй илэрхийлээд байгаа юм. Сонгуульд нэр дэвшигчдийн үнэмлэхийг Сонгуулийн тухай хуульд заасны дагуу санал авах өдрөөс 22 хоногийн өмнө буюу өчигдөр гардууллаа.

Сонгуулийн сурталчилгаа аравдугаар сарын 01-ний өдрөөс эхэлж, аравдугаар сарын 17-ныг дуустал явагдахаар холбогдох хуулинд тусгагдсан билээ.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



ҮЗЭЛ БОДОЛ

## Голсон юм голд гэдэг шүү дээ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Àè yààààà òóóèù íyóyyà ààéààà pì áy. Àè °í°°à°ð ààáíààñ ààèñ ò¿ðòóyí, ààðàí àòééàà- àíèíòíð áyòyæ yààà °°àà¿é yòàyyàèéí øóíàòàé çíðèèáí à °ðò°æ òyèì yàà-èòà¿éí òòéà òòóèèèè íyóyyà áóé. Óóóèù è íàì àéá òàì àààèíà.

Нийслэлийн Ардчилсан намын дарга **Э.Бат-Цир**

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

# ТАВАНТОЛГОЙГ ХЯТАДТАЙ ХОЛБОХ ТӨМӨР ЗАМ ХЯМРАЛЫГ ГЭТЛЭХ ГАРЦ УУ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Тодруулбал, Би Би Си агентлагийн мэдээлснээр, Монгол Улс 550 км урт шинэ төмөр зам тэргүүтэй хэд хэдэн төмөр замын төслүүдийг хэрэгжүүлж, Хятад болон Европын орнуудтай төмөр замаар холбогдох сонирхолтой байгаа аж. Гэвч ийнхүү талд гаднаас хөрөнгө оруулалт татаж, гадаад худалдааг хөгжүүлэх шаардлага бий болсон гэнэ. Одоогоор тус улсын авахыг хүссэн эзэлийн хэмжээ тодорхойгүй байгаа бөгөөд Монгол ч, Азийн дэд бүтцийн банк ч тайлбар хийгээгүй юм. Эдийн засгийн хямралд өртсөн Монгол Улс Хятадтай хиллэдэг дэлхийн хамгийн том Таван толгойн нүүрсний ордыг өмнөд хөрштэйгөө холбох төмөр замын бүтээн байгуулалтад эдүгээг хүртэл 200 сая ам.доллар зарцуулсан байдаг. Гэвч албаныхны хэлж буйгаар төмөр замын ажлыг бүрэн дуусгахад дахин 800 сая ам.доллар шаардлагатай гэнэ. Тиймээс тэд Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкнаас гадна өөр байгууллагаас ч хөрөнгө оруулалт татахаар ажиллаж эхэлсэн аж. Таван жилийн өмнө эдийн засгийн өсөлтөөрөө гайхагдаж явсан тус улс сүүлийн үед хямралтай нүүр тулаад буй. Тус улс 2014 онд Хятадтай стратегийн иж бүрэн түншлэлийн гэрээг байгуулж байсан бөгөөд АДББ-д ч гишүүнээр элсч байсан удаатай.

Гол экспортын бараа болох зэс, нүүрсний үнэ унаж, гадаадын хөрөнгө оруулалт багасч, үндэсний өрийн хэмжээ нэмэгдэн валютын хомсдол үүсч, ханш нь унасан. Тэгвэл эдийн засгийн хямралаас гарахын тулд тус улсын засгийн газар эзэлийн хүүгээ нэмж, төсвийн зардлаа бууруулж эхэлсэн бөгөөд мөн дэд бүтцийн гол төслүүдийн нэг Таван толгойн төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхээр ажиллаж эхэлжээ. Хэдийгээр Монголын тал уг бүтээн байгуулалтад зарцуулагдах санхүүгийн талаар тодорхой мэдээлээгүй ч, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банктай урьдчилсан байдлаар суудлыг хэлэлцсэн сурагтай. Ямартай ч, АДББ Монголын хүсэлтийн талаар тодорхой мэдээлэл хэвлэлд өгөхөөс татгалзсан. Гэхдээ Монгол АДББ-тай хамтын ажиллагаагаа сайжруулахаар мэрийж байгаа гэх мэдээлэл ор үндэслэлгүй биш. Шуудхан хэлэхэд үнэн.

Reuters.com: Тавантолгойн төмөр зам эдийн засгийг хямралаас гаргах гол төслийн нэг

Монгол, Хятад, Оросын өнгөрсөн зургадугаар сард байгуулсан эдийн засгийн коридорын тухай гэрээгээр бүс нутгийн төмөр замын тээвэрлэлтийг одоо байгаа замуудыг шинэчлэн тээвэрлэлтийн хэмжээг нь өсгөх, мөн шинэ чиглэлүүд барих замаар нэмэгдүүлэхийг

зорьжээ. Монгол Улс шинээр 550 км төмөр зам барих, одоо байгаа замаа өргөжүүлэх санхүүжилт авахыг эрмэлзэж байгаа аж. Үүний тулд тус улс хэдий хэмжээний мөнгө зээлэх нь одоогоор тодорхойгүй ч, Азийн дэд бүтцийн банктай энэ талаар хэдийнэ урьдчилсан хэлэлцээ хийсэн хэмээн Ё.Манлайбаяр хэлсэн юм. Гэвч Азийн дэд бүтцийн банкны хэвлэлийн төлөөлөгч энэ талаар ямар нэг мэдээлэл өгөхөөс татгалзсан.

Шинэ төмөр замын төлөвлөгөөндээ Австралийн нүүрс олборлогч “Aspire Mining” компанийн тэргүүлж буй Хойд чиглэлийн төмөр замыг дурьдаж болно. Хятадын хөгжлийн банк энэ бүтээн байгуулалтын гуравны нэгийг гаргах сонирхолтойгоо хэдийнэ мэдэгджээ. Үүнээс гадна Монголын төлөвлөгөөнд Тавантолгойн нүүрсний уурхайг Хятадын хилтэй холбох төмөр зам барих явдал багтаж буй. Монгол Улс энэхүү бүтээн байгуулалтад 200 сая ам.доллар зарцуулаад байгаа ч нэмж 800 сая ам.доллар шаардлагатай ажээ. Тавантолгойн төмөр зам нь эдийн засгийн хямралаас гарахыг тэмүүлж буй Монгол Улсын Сангийн яамны онцолж буй дэд бүтцийн таван гол төслийн нэг юм. Тус улсын Засгийн газар түүнчлэн Оюутолгойн зэс, алтны уурхай

дахь “Рио Тинто”-гийн далд уурхай, Канадын “Centerra Gold” компанийн Гачууртын алтны уурхай зэргийн бүтээн байгуулалтыг хөгжлийн үндсэн боломжуудынхаа нэг хэмээн үзэж байгаа аж.

business.sohu.com: Таван толгойн нүүрсний ордыг дахин хөдөлгөх төлөвлөгөөг аль хэдийнэ боловсруулсан

Зүүн хойд азийн далайд гарцгүй Монгол улс сүүлийн жилүүдэд эдийн засгийн хямралтай нүүр тулсан. Улмаар гадаад худалдаа болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн хямралыг гэтлэхийн тулд Таван толгойн нүүрсний ордыг дахин хөдөлгөх төлөвлөгөөг аль хэдийнэ боловсруулжээ. Гадаад хэргийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга Ё.Манлайбаярын хэлснээр тус улс Хятад, Европтой холбосон 550 км урт шинэ төмөр замын бүтээн байгуулалтад зориулан Азийн дэд бүтцийн банкнаас хөрөнгө оруулалт хүссэн аж. 2014 онд Монгол Улсын их хурал тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төслийг баталсан байдаг. Төмөр замын эл стандартаар барьснаар богино хугацаанд тээврийн компаниуд нэмэгдэх төлөвтэй хэдий ч, урт хугацаандаа Монголын эдийн засагт үлэмж хэмжээний ашиг авчирна хэмээн зарим орон нутгийн хэвлэлүүд бичиж байв. Ямартай ч, Гадаад хэргийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга Ё.Манлайбаяр боломжит хөрөнгө оруулагчидтай нэг нэгээр нь нүүр тулж уулзах төлөвлөгөөтэй байгаа юм байна.

www.bestchinanews.com: Хямралд өртсөн Монгол АДББ-аас тусламж хүсчээ

Таван жилийн өмнө эдийн засгийн өсөлт нь хоёр оронтой тоонд хүртлээ өсч байсан Монгол гүн хямралд өртсөн.



Төмөр дутлын цус багадаа аажим авцтай тул эхний шатанд ямар нэгэн шинж тэмдэг мэдэгддэггүй гэнэ. Харин цус багадаа хүчтэй илэрсэн үед хүн амархан идэрч, бие нь сульдаж, залхуу хүрдэг, уцаартай, толгой нь өвддөг, анхаарал төвлөрөлт мууддаг, царай нь цонхийж, байнга даардаг, ачааллын үед амьсгаа давчиддаг, халдвар амархан авдаг, судасны цохилт түргэсдэг гэх зэрэг зовиур илэрч эхэлдэг аж. Ийм эмгэгээс сэргийлэх, түүнээс салахын тулд цус төлжүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй болно. Тэгвэл бидний аль дээр үеэ “цус төлжүүлэгч” хэмээн нэрлэж, байнга хэрэглэдэг байсан улаан лооль цусыг шингэлдэг бөгөөд төмрийн агууламжаараа хамгийн багад тооцогддог юм байна. Харин төмрийг хамгийн ихээр агуулдаг хүнсэнд өлсөж үзээгүй монголчуудын “нохойн хоол” хэмээн цамаархаж, хэрэглэхээ больчихоод байгаа малын дотор гэдэс ордог аж. Тухайлбал, малын элэг, ясны тунгалаг шөл цус төлжүүлэхэд хамгийн сайн, гүзээ нь төрсөн ээжүүдийн хөхөнд сүү оруулна, харин дэлүү нойр булчирхайд хэрэгтэй, толгой шийр нь тэр чигтээ коллаген агуулдаг болохоор дотор гэдэснээс хаях зүйл огт байхгүй гэдгийг ойлгох цаг болж. Учир нь цус багадаагаас үүсэх үр дүн тийм ч хүсмээр эд биш гэдгийг одоо л ойлгохгүй бол хожимдоно. Муугаар бодоход 10, 20 жилийн дараа бүгд өвчинд нэрвэгдсэн байхыг ч үгүйсгэхгүй. Одоо өвчлөл улам залуужаад байгаа болохоор эртнээс л эрүүл мэнддээ анхаарах нь чухал байна. Тиймээс одоо голж шилж, хямсаганаад байлгүй дотор гэдэс, дайвар бүтээгдэхүүнээ л идээд байцгаая, бүгдээрээ.

## ЭДИЙН ЗАСАГ

ЭДИЙН ЗАСАГЧ ЯРЬЖ БАЙНА



...Мэдэгдэл хүргүүлэхээс өмнөх таван хувийн зээлүүдийн хүсэлтийг шийдвэрлэж өгөхийг банкууд хүссэн байгаа. Энэ хүсэлтийн дагуу Монголбанкнаас 2016 оны есдүгээр сарын 14-ний байдлаар ирүүлсэн 1948 зээлдэгчийн 92.2 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэсэн...

## Б.ТҮМЭНЦЭНГЭЛ:

## 1948 ХҮНИЙ ТАВАН ХУВИЙН ЗЭЭЛИЙН ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭЖ ӨГӨХӨӨР БОЛСОН

Н.ПУНЦАГБОЛД

Монголбанкны эдийн засагч Б.Түмэнцэнгэлтэй ипотекийн зээлийн асуудлаар цөөн хорм ярилцлаа.

-Монголбанкнаас ипотекийн зээлийг санхүүжүүлэх тал дээр тодорхой байр суурийг баримталж байгаа. Таван хувийн зээлийг олгох боломжгүй гэдгээ мэдэгдсэн. Найман хувийн зээлийн хувьд түр зуур олгохоо больчихоод байна?

-Монголбанк бол ипотекийн зээлийг үргэлжлүүлэх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Гэхдээ цаашид хэрхэн, тогтвортой, зөв механизмаар үргэлжлүүлэх вэ гэдэг гарцгүй хайж байна. Үүнийг бас иргэд ойлгох хэрэгтэй. Таван хувийн зээлийг яагаад олгох боломжгүй болчихов гэдэг дээр иргэд нэлээд сонирхож байна. Таван хувийн зээл өнөөгийн нөхцөлд энэ байдлаар үргэлжлэх боломжгүй. Мөнгөний бодлогын нийцтэй байдалтай уялдахгүй байна. Нэг талдаа эрс шийдэмгий арга хэмжээ аваад, чангалах бодлого явдаг. Нөгөө талдаа таван хувийн зээл санхүүжүүлэх гээд мөнгө хэвлэдэг байдал нь хоорондоо нийцтэй биш. Тэгэхээр таван хувийн зээлийг зогсооё гэсэн шийдвэрийг Монголбанкнаас гаргасан байгаа. Найман хувийн зээлийн хувьд цааш нь хэрхэн үргэлжлүүлэх вэ гэдэг арга замыг бид хайж байна.

-Таван хувийн зээл авахаар нэгэнт хүсэлтээ өгсөн хүмүүст зээл олгох асуудал яригдсан гэсэн. Энэ талаар тодруулбал?

-Монголбанкны Захирлуудын зөвлөлөөс таван хувийн

хүүтэй орон сууцны зээлийн санхүүжилтийг зогсоох шийдвэр гаргаж, 2016 оны есдүгээр сарын 5-ны өдөр бүх банкны гүйцэтгэх захирлуудад мэдэгдсэн. Тухайн мэдэгдэл хүргүүлэхээс өмнөх таван хувийн зээлүүдийн хүсэлтийг шийдвэрлэж өгөхийг банкууд хүссэн байгаа. Энэ хүсэлтийн дагуу Монголбанкнаас 2016 оны есдүгээр сарын 14-ний байдлаар ирүүлсэн 1948 зээлдэгчийн 92.2 тэрбум төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэсэн. Гэхдээ хоёр үе шаттайгаар олгохоор шийдвэр гарсан. Эхний ээлжинд нэн тэргүүнд олгох үндэслэл бүхий 739 зээлдэгчийн 44.7 тэрбумыг олгохоор болсон. Үүнд, худалдан авах орон сууцных нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ гарсан, банк зээлдэгчтэй зээлийн гэрээ болон барьцааны гэрээ байгуулсан, зээлдэгчийн барьцааг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт

хугацаа хэлэхэд хэцүү байна. Яг тэднээс эхэлж өгнө гэж хэлэх аргагүй. Гэхдээ бид аль болох шуурхай арга хэмжээ авч, хурдан шийдвэрлэх тал дээр ажиллаж байна.

-Засгийн газраас 100 ам.метр хүртэл талбайн хэмжээг нэмэх талаар яриад байгаа шүү дээ. Энэ тал дээр Монголбанкны зүгээс ямар байр суурьтай хандаж байгаа юм бол?

-Ер нь бол гуравдугаар сараас эхлээд ипотекийн зээлийн үйлчлэлийг Засгийн газарт шилжүүлсэн. Тийм болохоор энэ хөтөлбөрөө ямар нөхцөлтэйгээр үргэлжлүүлэх нь Засгийн газрын өөрийнх нь шийдэх асуудал. Монголбанкны хувьд санхүүжилт талаас нь оролцож байгаа. Манай байр суурь ямар вэ гэхээр, 80 хүртэлх ам.метр талбайтай орон сууцны ипотекийн зээлийг бид санхүүжүүлнэ. Түүнээс дээш бол Засгийн газар хэрхэн санхүүжүүлэх шийдлээ өөрөө ол гэсэн байр суурьтай байгаа.

МЭДЭЭЛЭЛ

## Ажилгүй иргэдийг мэргэшсэн жолоочийн ажлын байраар хангана



М.ДАВАА

Энэ оны эхний наймдугаар сарын байдлаар улс хооронд автотээврээр тээвэрлэсэн 13.2 сая тонн ачааны 11.8 мянган тонныг нь нүүрс тээвэрлэлт эзэлж байгаа судалгаа бий. Үүнээс уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.4 хувиар өссөн үзүүлэлттэй байгааг харж болно. Тухайлбал, уул уурхайн бүтээгдэхүүнийг 2016 оны найман сарын байдлаар авч үзвэл нүүрс 11854.6 мянган тонн, газрын тос 696.2 мянган тонн, зэсийн баяжмал 644.3 мянган тонн, төмрийн хүдэр 12.9 мянган тонн тус тус экспортложээ.

Цаашид нүүрсний эрэлт нэмэгдэж байгаагаар холбоотойгоор тээвэрлэлтийн үйл ажиллагаа идэвхжих хандлагатай байгаа юм. Өнөөдрийн байдлаар улс хоорондын 10 чиглэлд байнгын ачаа тээвэрлэлтийг 130 аж ахуйн нэгж, байгууллага, 4200 гаруй тээврийн хэрэгсэл 4552 жолооч тээвэрлэлт гүйцэтгэдэг. Тээвэрлэлтийн хэмжээ нэмэгдэж байгаагаар холбогдуулан автотээврийн салбарт улс хоорондын ачаа тээврийн үйлчилгээнд ажиллах жолоочийн эрэлт нэмэгдэж байна. Тиймээс Зам, тээврийн хөгжлийн яамнаас автотээврийн салбарт дутагдалтай байгаа мэргэшсэн жолоочийн ажлын байранд ажил хайж буй иргэдийг

хамруулахаар болжээ. Энэ хүрээнд Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллаж байгаа бөгөөд хөдөлмөрийн биржид бүртгэлтэй, ажилгүй иргэдийг ажлын байраар хангахад боломжтой болж байгаа юм.

Одоогийн байдлаар улс хоорондын тээвэрлэлтийн үйлчилгээ эрхэлж буй 37 аж ахуйн нэгж байгууллагаас 460 гаруй жолооч шаардлагатай байгаа талаарх судалгааг Зам, тээврийн хөгжлийн яаманд ирүүлсэн талаар албаныхан хэлж байна.

Автотээврийн тухай хуульд зааснаар тухайн тээвэрлэлтийг гүйцэтгэхэд зохих ангиллын мэргэшсэн жолоочийг ажиллуулахаар заасан бөгөөд батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авсан байх шаардлага тавьдаг аж. Статистикийн мэдээгээр 2016 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт салбаруудын сарын дундаж цалин 888 мянган төгрөг байгаа бол мэргэшсэн жолоочийн дундаж цалин 1.2 сая орчим байхаар ажлын байрны захиалга ирүүлжээ. Мөн улирлын ажиллах хүчний судалгааны дүнгээр улсын хэмжээнд ажилгүй иргэд 131300 байгаагаас хөдөлмөр нэмэгдэж байна. Тиймээс Зам, тээврийн хөгжлийн яамнаас автотээврийн салбарт дутагдалтай байгаа мэргэшсэн жолоочийн ажлын байранд ажил хайж буй иргэдийг



## МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд

64

дугаар

Захиалгын үнэ

18000



Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out



# ИРГЭД ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД СӨРӨГ ХҮЧИНГ ДЭМЖИНЭ

Н.БАТЗАЯА

УИХ, НИТХ-ын сонгуульд МАН үнэмлэхүй ялалт байгуулан ялагч болсон. Гэсэн хэдий ч сонгуулийн дараа иргэд амаа барьцгаасан. Түүнийг дагаад орон нутгийн сонгуульд Ардчилсан нам ялна гэх тайлбарыг мэргэжилтнүүд ч хийж буй. Тиймээс орон нутгийн сонгуульд ямар намд саналаа өгөх талаар иргэдээс "Speak out" авлаа.

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



Д.Тогтох: Орон нутгийн сонгуульд Ардчилсан намыг дэмжинэ

-Би Ардчилсан намыг дэмждэг. Өнгөрсөн сонгуулиар ч гэсэн Ардчилсан намыг дэмжиж байсан. Одоо ч дэмжиж байгаа. Саяны сонгуулийн үр дүнд МАН ялалт байгуулсан. Тэд УИХ-д ч, НИТХ-д ч олонхи болж чадсан. Хэтэрхий олонхи болчихоор буруу шийдвэр гаргаад байна. Тэднийг эсэргүүцэж, санал бодлоо илэрхийлэх хүнгүй болчихлоо шүү. Би орон нутгийн

сонгуульд Ардчилсан намыг дэмжинэ. Өнгөрсөн хугацаанд ч гэсэн Ардчилсан нам олон ажлыг хийсэн гэж боддог. Хийсэн ажил нь бидний нүдэн дээр илт байгаа. Нийтийн тэвэр ямар байсан билээ. Бид өмнө нь хоорондоо хэрэлдсэн, чихэлдсэн тийм л замбараагүй байдалд нийтийн тэвэрээр зорчдог байсныг бүгд л мэднэ. Гэтэл одоо ямар болсон байна. Ямар ч хэрүүл, маргаан,

стрессгүй үйлчлүүлж байгаа. Мөн замын ажлыг сайн хийсэн. Баруун таван аймаг руу хар зам тавьсан. Түүнийг дагаад машинтай хүн бүр л хөдөө орон нутаг руу аялал, зугаалганд явдаг болсон. Өмнө нь бид юун тэгж 6-7 цаг яваад Өвөрхангай орох, нэг, хоёр хоног л явдаг байсан. Ер нь бодоод байхад бидний амьдралд олон зүйл өөрчлөгдсөн санагддаг. Яах вэ

олон төрлийн байгаа. зарим нь хүний хийсэн ажлыг олж хардаг, олж хардаггүй ч хүн бий. Би залуу хүнийхээ хувьд Ардчилсан намын хийсэн ажилтай, үзүүлэх бүтээн байгуулалттай л гэж дүгнэдэг. Өнгөрсөн сонгуулиар яагаад тэгж ялагдсныг мэдэхгүй. Уг нь хүн бүр л хийсэн ажлыг нь мэдэж байсан ч ялагдчихсан. Энэ удаад орон нутгийн сонгуульд Ардчилсан намыг гараасай

гэж хүсч байна. Тэгж байж бид сөрөг хүчинг бүрдүүлж чадна. Олонхи болон сөрөг хүчиний тоог тэнцүүлэхгүй бол арай болохгүй шиг санагдсан. Иргэд ч ийм л хандлагатай байгаа байх.



Н.Очир: Дүүргийн ИТХ-д Ардчилсан намд саналаа өгнө

олонхи болсон. Тэгэхээр орон нутгийн сонгуульд, дүүргийн ИТХ-д Ардчилсан нам гарсан нь дээр гэж би бодож байгаа. Би хувьдаа тийм байр суурьтай явдаг. Нэг нам хэтэрхий олонхи байх нь тийм ч сайн талтай биш. Эхнээсээ гаргаж байгаа шийдвэрүүдээс харагдаж байгаа байх. Гэхдээ үнэхээр хийж чадаж байвал аль ч нам гарсан яах вэ дээ. Бодоод үз л дээ. Нэг тэрбум гаруй хүн амтай хятад улс байна. Тэр улсыг бас нэг нам л удирдаад явж байгаа шүү

дээ. Тэгэхэд гурван сая хүн амтай Монгол Улсаа хөгжүүлэх бодолтой хүмүүс гарсан нь дээр. Манай улс гуравхан сая хүнийг авч явах чадвартай, толгойтой нам л хэрэгтэй. Хэрвээ тухайн нам сайн ажиллавал бидний амьдрал дээшилнэ. Мөн тэдний ажлаар манай улсыг олон улсад үнэлж, дүгнэнэ. Би тийм л бодолтой явдаг. Өнгөрсөн дөрвөн жилд Ардчилсан нам бүтээн байгуулалтын ажлыг сайн хийсэн. Ялангуяа Э.Бат-Үүл дарга маш сайн ажилласан.

Хүний хэрэгжүүлэггүй, зориг гаргаагүй ажлыг хийж чадсан. Сайхан зам тавилаа, энд тэндхийн уулзваруудыг шинэчиллээ. Энэ бүх ажлыг зориг гаргаж хийлээ шүү дээ. Өөр намынхан энэ ажлыг хийж чадаагүй. Манай гишүүдэд нэг муухай зан байдаг. Мэдээ сонсож байхад ажиглагдах л даа. Тэр нь юу гэхээр хийж байгаа нэгнээ үргэлж доош нь дардаг. Өөрсдөө тийм зүйл хийж чадахгүй байж битгий тэг. Аль эсвэл өөрсдөө хийчихээд, бүтээн байгуулчихаад

адилхан уралц. Хоёр хүн хоёулаа хийгээд явбал том дэвшил гарна даа. Гэтэл манайхан нийлээд хамт хийхийн оронд нэгнээ заавал доош нь дардаг муухай зантай. Тур тусмаа юм сайн хийж чадаж байгаа нэгнээ дардаг. Ардчилсан намд хийсэн ажлууд бий. Тухайлбал, манай гудамж өмнө нь гэрэлтүүлэг муутай, шөнө орой хүүхэд, эмэгтэйчүүд явахад хэцүү л байсан. Одоо харин гэрэлтүүлэгтэй болсон. Манай энэ орчим гэлтгүй хүн бүрийн мэддэг Саппорогийн

уулзварыг л хар. Тэр уулзвар өмнө нь ямар байлаа. Хүмүүс эр зоригийн тойрог гэж л ярьдаг байсан. Тийм байсан уулзварыг хэчнээн сайхан болгосон билээ. Одоо иргэдийн төлөөлөгчдийн сонгуульд Ардчилсан намд саналаа өгнө. Тэр нь ч дээр. МАН гараад хийсэн ажил юу байна. Юу ч байхгүй. Тиймээс ИТХ-д Ардчилсан намыг гаргавал ядаж л дүүрэг хөгжих магадлалтай.



Г.Ганболд: Дүүргийн ИТХ-д Ардчилсан намын нэр дэвшигчид саналаа өгөхөөр шийдсэн

-Ард түмэн МАН-д саналаа өгөхдөө сайн ажиллаасай, мөрийн хөтөлбөртөө үнэнч байгаасай гэж хүсч л гаргасан. Би ч өөрөө МАН-ын М.Оюунчимэг гишүүнд саналаа өгсөн. Ер нь ард иргэд сайн ажил хийчих болов уу гэсэн хүндээ л саналаа өгдөг. Би ч бас тэгж бодож саналаа өгсөн. Гэхдээ саналаа өгснийхөө дараа эргээд харахад буруу сонголт

хийсэн нь мэдрэгдэж байна. УИХ-ын гишүүдийн гаргасан шийдвэрүүдийг харахад, нэг их явцгүй санагдсан. Тиймээс дүүргийн ИТХ-д Ардчилсан намын нэр дэвшигчид саналаа өгөхөөр шийдсэн. Яагаад гэвэл өнгөрсөн хугацаанд Ардчилсан нам олон ажлыг хийж чадсан. Бид харин ниргэсэн хойно нь гэгчээр одоо л амаа барьж байна. Дахиад амаа барихгүйн тулд энэ удаад Ардчилсан намд саналаа өгнө. Мэдээж

Ардчилсан нам замын ажлыг маш сайн хийсэн. Энэ ажлаасаа ч иргэдээс сайн үнэлгээ авч байгаа шүү дээ. Мөн олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Миний бодлоор "Сайн хашаа" хөтөлбөр болмоор юм шиг санагдаж байсан юм. Гэр хорооллын айлууд өөрийн хашаандаа инженерийн шугам сүлжээтэй болох бүрэн боломжтой. Сая МАН уг хөтөлбөрийг үргэлжлүүлэхгүй гэдгээ

мэдэгдсэн. Бидний амьдралд хэрэг болсон нэг ажил нь гэрэлтүүлэг. Гэр хорооллын айлуудад гэрэлтүүлгийн асуудал маш чухал байдаг. Шөнө орой тардаг ажилтай хүмүүс ч бий. Ялангуяа өвлийн улиралд үнэхээр хэцүү. Замаа харахгүй хальтарч уначих гээд их эвгүй. Одоо харин манай гудамж гэрэлтүүлэгтэй болсон. Энэ ажлыг хийсэнд их баярлаж байгаа. Би бас нэг юмыг бодоод олдоггүй

юм. Энэ УИХ-ын гишүүдэд улс төрийн соёл гэж баймаар. Хүн уг нь гаргасан алдаан дээрээсээ сурацдаг биз дээ. Гэтэл тэгдэггүй. Яг л хэвээрээ л байгаад байна. МАН дөрвөн жилийн өмнө ямар байсан тэр л хэвээрээ. Энийг л бодоод ойлгохгүй байгаа юм.



П.Чойроо: Миний бодлоор нэг нам хэтэрхий олонх байх хэрэггүй

-МАН үнэхээр иргэдийн итгэлийг алдлаа. Сая гаргасан шийдвэрүүд нь тийм ч сайн байгаагүй. Тиймээс цаашид МАН олонхи байна гэдэг асуудалтай. Одоо болох дүүргийн ИТХ-ын сонгуульд Ардчилсан намд саналаа өгнө. Түүн дээр ярих зүйл байхгүй. МАН ард түмнээс нүүрээ буруулсан шүү дээ. Засгийн эрхийг авсан. Тэгээд л мөрийн

хөтөлбөрөөсөө өөр зүйл ярьж эхэлсэн дээ. Энийг бүгдээрээ харж байгаа. Миний бодлоор нэг нам хэтэрхий олонхи байх хэрэггүй. Үүний жишээ МАН. Яаж авирлаж байгааг нь харж байгаа биз дээ. Ер нь төр засгийн удирдлага, намын эрх мэдлийг тэнцвэржүүлж байх хэрэгтэй. Монголын ард түмэн л зөв сонголтыг хийж, зөв шийдвэр гаргах ёстой.

Нэг ёсондоо ард иргэдэд харууцлагатай үүрэг оногддог гэсэн үг. Тиймээс би иргэн хүнийхээ хувьд дүүргийн ИТХ-д Ардчилсан нам олонхи болоосой гэж бодож явдаг юм. Ингэж байж хоёр нам тэнцвэртэй байна. Ардчилсан нам орон нутагт явбал ядаж хөдөө орон нутаг дахь сөрөг хүчин нэмэгдэнэ. Одоо бол УИХ, НИТХ-д сөрөг хүчин

бараг байхгүй. Бүгдэд нь МАН олонхи болсон. Тэгэхээр бид энэ байдлыг л тэнцвэржүүлэх хэрэгтэй. Сөрөг хүчин байхгүй бол МАН-ын гаргасан шийдвэр болгон хэрэгжинэ шүү дээ. Тиймээс сөрөг хүчин чухал.



О.Батзориг: МАН хэлсэн ярьснаасаа огт өөр зүйл хийж байна

-Ер нь аль ч нам адилхан. Гарахаасаа өмнө олон сайхан зүйлийг амладаг. Гарсныхаа дараа юу ч хийдэггүй, амлалтандаа ч хүрдэггүй. Энэ бол нийтлэг үзэгдэл. Манай Чингэлтэй дүүргийн есдүгээр хороонд 10 жилийн өмнө ийм л байсан. Одоо ч

хэвээрээ л байна. Ганц нэг гүүр л нэмэгдсэн байх. МАН сонгуулийн өмнө олон сайхан зүйлийг л амлаж байсан. Одоо хар л даа. Хэлсэн, ярьсан зүйлээсээ огт өөр зүйлийг л хийж байна.

# ДЭЛХИЙ



## Доналд Трамп VS Хиллари Клинтон

Б.ДАВААХҮҮ

Дэлхийн нэгэн хүчирхэг гүрэн болох АНУ-ын дараагийн Ерөнхийлөгч ирэх арваннэгдүгээр сарын 8-нд тодорно. Энэ

сонгуульд Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нэр дэвшиж байгаа. Тэд хоёулаа эрс тэс туршлагатай.

Хиллари Клинтоны хувьд улс төрийн арвин туршлагатай бол Доналд Трамп бизнесийн хүрээнд туршлага хуримтлуулагч чадсан нэгэн юм. Ямартай ч, тэдний анхны халз мэтгэлцээн дэлхий нийтийн анхаарлыг татаж, нийтдээ

100 сая орчим хүн шууд хүлээн авч үзсэн. Тиймээс халз мэтгэлцээний талаар хэд хэдэн хэсэг болгон уншигчиддаа сонирхуулахаар бэлтгэлээ.

...Трамп татвар төлсөн баримтаа ил зарлаж байгаагүй хэмээн Ардчилсан намаас нэр дэвшигч илчилсэн. Харин тэрбээр “Надад санаа зовоод байх зүйл байхгүй. Татвараа байнга шалгуулдаг. Хүсвэл нийтэд зарлаж болно” гэв. Ийнхүү хэлснийхээ дараа Клинтон хувийн имэйлын талаархи асуудлыг сөхөж, “Би татварын баримтаа дэлгэж болно. Гэтэл Хиллари 33 мянган имэйлээ устгасан шүү дээ” гэсэн юм...

### 1. Мэтгэлцээн нөхөрсөг эхлэв, гэхдээ нэг нэгийгээ шоглохоос зайлхийсэнгүй

Хиллари Клинтон, Доналд Трамп нар олон сарын хугацаанд нэг нэгийнхээ бодлогыг шүүмжлэн, доромжилсон ширүүн дайралт хийж байв. Гэхдээ энэ үдэш тэд өрсөлдөөнөө дотроо нууж, нөхөрсөг байдлаар халз мэтгэлцээнийг эхлүүлэхийг хичээж байлаа. Гэхдээ энэ удаа нэр дэвшигчид намын бэлгэ тэмдэг болсон өнгөө сольж өмссөн мэт харагдаж байсныг зарим эх сурвалж онцолсон юм. Тодруулбал, Клинтон улаан өнгийн дашинз өмссөн байсан бол Доналд Трамп хөх өнгийн зангиа зүүсэн байлаа. Улмаар танхимд орж ирмэгцээ гар гараасаа барьж, Хиллари “Сайн уу, Доналд?” гэж мэндчилсэн. Дараа нь Трамп гадаад худалдааны талаар яриагаа эхлүүлж, “Клинтон дарга бүх зүйлд шударга хандсан” гэж хэлээд “Тийм үү. Би чамайг жаргалтай байгаасай гэж хүсч байна. Энэ миний хувьд маш чухал” хэмээв. Гэхдээ тэрбумтан эр ярианыхаа үеэр “Ерөнхий нарийн бичгийн дарга Клинтон” гэх үгийг давтан хэлж, шоглоод амжсан.

### 2. Хувийн амьдрал руу нь чиглэсэн довтолгоон

Хиллари Клинтон Доналд Трамп руу чиглэсэн анхны довтолгоон түүний бизнестэй холбоотой байв. Төрийн нарийн бичгийн дарга асан тэрбээр эцгээсээ 14 сая ам.доллар зээлж бизнесээ эхлүүлсэн гэж хэлсэн юм. Тэрбээр “Доналд өөрийн сайн сайхны төлөөх бүхий л үйл явдалд маш азтай байсан. Тэр эцгээсээ 14 сая

ам.доллар зээлж бизнесээ эхлүүлж байсан. Тиймээс ч чинээлэг хүмүүст туслах туйлын хүсэлтэй байгаа. Би бүхнийг худалдан авч чадахгүй. Яагаад гэвэл би түүнээс огт өөр амьдралыг туулсан болохоор...” гэж ярьжээ. Харин үүний хариуд Трамп “Энэ талаар ярихын өмнө 1975 онд би ааваасаа маш бага хэмжээний мөнгө зээлж бизнесээ эхлүүлж байсан юм. Харин компаниа улам өргөжүүлж, хөрөнгийн хэмжээг хэдэн тэрбум ам.доллар болтол нь өсгөж чадсан” хэмээн хариулж, мад тавьсан юм.

### 3. Гадаад худалдааны гэрээг хөндөв

Сонгогчдын заавал үзэх ёстой хэсгийн нэг нь нэр дэвшигчдийн Транс-Номхон Далайн Түншлэлийн гэрээний талаархи мэтгэлцээн байсан юм. Номхон далайн эрэг дагуух АНУ тэргүүтэй бусад 11 орны худалдааны тухай Транс-Номхон Далайн Түншлэлийн гэрээг Хиллари Клинтон дэмжиж буйг Доналд Трамп эрс шүүмжилсэн. Тэрбээр “Та одоо ч Номхон далайн түншлэлийн гэрээг батлахыг хүсч байгаа. 100 хувь гэрээг дэмжиж байсан шүү дээ” гээд “Худалдааны гэрээний алтан стандарт” гэж байдгийг Клинтонд сануулав. Харин Хиллари “Яах вэ Доналд, би чиний амьдралыг мэднэ. Гэхдээ бодит байдал дээр огт өөр” гэж хариулсан юм. Тэрбээр Ерөнхийлөгч Барак Обамагийн удирдлага дор Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хашч байхдаа Транс-Номхон Далайн Түншлэлийн Гэрээг сурталчилж байснаа хүлээжээ. 2012 оны арваннэгдүгээр сарын 15-нд Австралид болсон уулзалтад “Транс-Номхон

Далайн Түншлэлийн Гэрээнд худалдааны алтан стандарт болох нээлттэй, чөлөөт, шударга, хуулийг дээдэлсэн байдлыг тусгасан” гэж хариуллаа.

### Трампын галзуу ганц үг

Мэтгэлцээн хагас цаг орчим үргэлжилсний дараа тэдний яриа сэдвээсээ хальж, Лалын улс бүлэглэл, татвар, эдийн засаг гэх мэт өргөн хүрээг хамарч эхэлсэн. Гэвч тэр бүрт Доналд Трамп Хиллари Клинтонд бүх бурууг тохохыг хичээж, “Яагаад үгүй гэж” гэх үгийг давтан хэлж байсан юм. Харин энэ үед Хиллари “Энэ үдэш надад бүх л зүйлд би буруутан байсан юм шиг тийм мэдрэмж төрлөө. Өмнө нь ийм мэдрэмж хэзээ ч төрж байгаагүй юм байна” гэж хошигноход Трамп урьдын л адил “Яагаад үгүй гэж” гэх үгээ дахин хэлж байлаа. Үүний хариуд Хиллари “Яагаад үгүй гэж, тийм ээ. Яагаад үгүй гэж. Мэтгэлцээний ганц галзуу үг” хэмээн хошигноод амжив. Харин Трамп “Манай компаниуд улсдаа мөнгөө эргүүлэн авчрахгүй байхад галзуу зүйл байхгүй” хэмээн ярианд оролцож эхэлжээ.

### Трампын татварын бодлого шүүмжлэл дагууллаа

Тэгвэл мэтгэлцээний үеэр Хиллари үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трампын эдийн засгийн талаархи баримтлах бодлогыг дунд давхаргынхныг золиосолж, баячуудыг дэмжинэ хэмээн эрс шүүмжилжээ. Тодруулбал, Трампын татварын бодлогыг тэрбээр эдийн засгийн “Tickle

down” онолын хувилбар гэж тодорхойлсон бөгөөд баячуудад ногдуулах татварыг хамгийн их төвшинд хүртэл нь бууруулах гэж буйг шүүмжилсэн байна. Түүнчлэн тэрбээр үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан эр өөрийн эрх ашигт нийцүүлсэн бодлого баримталж буйг нээлттэйгээр хөндлөө.

### Трампын татварын баримттай холбоотойгоор мад тавиулав

Трамп татвар төлсөн баримтаа ил зарлаж байгаагүй хэмээн Ардчилсан намаас нэр дэвшигч илчилсэн. Харин тэрбээр “Надад санаа зовоод байх зүйл байхгүй. Татвараа байнга шалгуулдаг. Хүсвэл нийтэд зарлаж болно” гэв. Ийнхүү хэлснийхээ дараа Клинтон хувийн имэйлын талаархи асуудлыг сөхөж, “Би татварын баримтаа дэлгэж болно. Гэтэл Хиллари 33 мянган имэйлээ устгасан шүү дээ” гэсэн юм. Харин АНУ-ын нэр дэвшигч “Огт өөр сэдвээр жишээ татчихлаа. 40 жилийн турш Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж буй хэнбугай ч татварын баримтаа ил тод зарлах ёстой. Өөрөөсөө яагаад татварын баримтаа дэлгээгүй юм бэ гэж асуу л даа. Магадгүй өнөө орой түүнийг харж байгаа хүмүүст тэр нэг ч төгрөгийн албан татвар төлөөгүй гэдгээ харуулахыг хүсээгүй байх” хэмээн сөрөг дайралт хийсэн байна.

### Хиллари Клинтон: Би Ерөнхийлөгч болохын тулд өөрийгөө бэлтгэсэн

Доналд Трамп Хиллари кампанит ажлаасаа түрхэн зуур

чөлөө авч, мэтгэлцээнд бэлтгэж байсан хэмээн шүүмжилсэн юм. “Би маш олон газраар явсан. Харин чи гэртээ сууж байгаад мэтгэлцээндээ бэлтгэсэн” гэсэн бол Хиллари “Доналд энэ мэтгэлцээнд бэлтгэхдээ зөвхөн намайг яаж шүүмжлэх талаар л бэлтгэсэн бололтой. Тийм ээ. Би сайн бэлтгэсэн. Намайг хэрхэн бэлтгэж байсан талаар өөр зүйл мэдэх үү. Би Ерөнхийлөгч болохын төлөө бэлтгэж байна. Үүнийг тийм ч буруу зүйл гэж бодохгүй байгаа” гэжээ. Ерөнхийдөө мэтгэлцээний туршид Хиллари үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан эрийг хүнд хэцүү асуудлыг шийдвэрлэх, тэр дундаа Ерөнхийлөгч болоход бэлэн бус байгааг харуулахыг зорьж байв.

### Мэтгэлцээний зочид анхаарал татлаа

Доналд Трамп болон Хиллари Клинтон нарын дагуулан ирсэн хүмүүс ч олны анхаарлыг нэлээд татлаа. Тодруулбал, Хиллари энэ удаад нөхөр Билл Клинтон, охин Челсигээ дагуулан ирсэн бол Трамп эхнэр Милани болон хүүхдүүдээ авчирчээ. Үүнээс гадна мэтгэлцээн эхлэхээс эхлээд төгсгөл хүртэл өрсөлдөгчийнхөө сул талыг хөндөн буулган авахыг хичээж байсан Трамп нэгэн онцгой зочдыг урьсан байв. Тэр нь Хиллари АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байх үед Ливийн Бенгазида гарсан тус улсын Элчин сайдын яамыг онилсон халдлагын амьд гэрчүүд юм. Тэрбумтан эр улс төрийн асар их туршлага бүхий бүсгүйн бодлого алдаатай байсныг урьсан зочдоороо дамжуулан илэрхийлэхийг хүсчээ.

MMINFO.

Тал нутгийн цахим мэдээлэл



## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

# ХҮҮХДЭЭРЭЭ ЭЭЖ БОЛСОН НЬ ОХИДЫН БУРУУ БИШ, ХАРИЖ...

Ж.ОТГОНМЯГМАР

*Өсвөр насныхны жирэмслэлт гэдэг асуудал ганцхан манай улсад төдийгүй олон улсын өмнө тулгалдсан асуудал болоод байна. Өөрөөр хэлбэл, өсвөр үеийнхэнд тохиолддог олон эдрээтэй асуудлын нэг нь яах аргагүй охидын жирэмслэлт болчихлоо. Мэдээж өсвөр насандаа төрөх нь охидод төдийгүй тэдний гэр бүлийнхэнд тийм ч таатай биш байдаг. Ялангуяа сурч боловсрох, ирээдүйд сайхан амьдрах боломжоо алдаж, цаашид ажилгүйдэл, ядууралд өртөх эрсдэлтэй. Тиймээс өсвөр насны охидын жирэмслэлт, төрөлтийн төвшин, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт зэргийг бууруулах гарц, шийдлийг хайж “Монголын мэдээ” сонин энэ удаагийн дугаарын сурвалжлагаа бэлтгэвээ.*



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

“9-10 дугаар ангийн сурагчид аль хэдийн бэлгийн харьцаанд орсон байна”

Өнгөц харахад өсвөр насныхны жирэмслэлт гэдэг асуудал хэн нэгэн охинд тулгарч буй хувийн асуудал мэт харагдаж болох юм. Гэхдээ хачир дээрээ ганцхан охины асуудал биш. Энэ нь нийгмийн олон салбараас хамаарч байна. Тухайлбал, Япон улсын Засгийн газар Жайка олон улсын байгууллагаас хэрэгжүүлж эхлээд байгаа Өсвөр үеийнхний эрүүл аж төрөх дадалд суралцуулах тогтвортой тогтолцоо байгуулах төслийн хүрээнд охидын жирэмслэлтийн асуудлыг судалж үзсэн байна. Энэхүү судалгаагаар өсвөр насны охидын жирэмслэлт болон бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсөн тохиолдол гэр хороололд илүү олон байсан аж. Түүнчлэн 7-8 дугаар ангийн сурагчид дотор бэлгийн харьцаанд орсон тохиолдол цөөн байсан байна. Харин 9-10 дугаар ангийн сурагчдаас бэлгийн харьцаанд орсон тохиолдол олон байсан гэнэ. Энэ нь сургууль дээрээ болон гэр бүлийн орчинд нөхөн үржихүйн мэдээлэл авах боломж дутмаг байгаагаас болж байна гэдгийг тогтоосон байна. Энэ талаар БШПУСЯ-ны Боловсролын бодлогын газрын Суурь, бүрэн дунд боловсролын хэлтсийн дарга С.Болормаа “Энэхүү бодит байдлын судалгааны үр дүнд үндэслэн хэд хэдэн дүгнэлтийг хийсэн байгаа. Өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар нуцацгүй, зөв мэдлэг мэдээлэл өгөхийн тулд тэдний үе тэнгийнхнээр дамжуулан боловсрол олгох зайлшгүй шаардлагатай байна гэсэн дүгнэлт гарч ирсэн. Түүнчлэн төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр зорьж буй “Үе тэнгийн зөвлөхийн үйл ажиллагаа”-г зохион байгуулахын тулд дүүрэг, хороо, яамдынхаа төвшинд эрүүл мэндийн ажилтнууд болоод багш сурган хүмүүжүүлэгчид болон гэр бүлтэй нь хамтарсан ажил зохион байгуулах шаардлага байна гэдгийг тогтоогоод байна. Мөн хүүхдийг бүр багаас нь нөхөн үржихүйн боловсролыг болон гэр бүл төлөвлөлтийг ухаалгаар зааж сургах нь зүйтэй гэдэг гэдэг дүгнэлтүүдийг гаргасан” гэлээ. Уг нь энэ судалгаатай, судалгаагүй олон улсын сайн туршлага олон байгаа. Учир нь өсвөр насны охидын жирэмслэлтийг дагаад чанаргүй төрөлт, ядуурал, үр хөндөлтийн тоо цаашлаад бэлгийн замын



...2015 онд нийт 80.434 эх амаржсаны 5.5 хувийг 20 хүртэлх насны эхчүүд эзэлсэн, Үр хөндөлт хийлгэсэн эмэгтэйчүүдийн 5.1 хувийг 20-иос доош, 70 хувийг 20-34 насныхан эзлэж байна. Түүнчлэн бэлгийн замаар дамжих халдвараар өвчлөгсдийн 43.4 хувь нь 15-24 насны залуучууд байгаа зэрэг сэтгэл түгшим мэдээлэл цацагдаад байна...



халдварт өвчний тархалт нэмэгддэг. Тиймээс ч улс орон бүхэн өөр өөрсдийн гэсэн арга туршлагыг хэрэгжүүлдэг. Ингэхдээ ихэнхдээ хүүхдүүдэд багаас нь нас насны онцлогт нь тааруулсан бэлгийн боловсролын хичээлийг системтэйгээр заадаг. Гэтэл манайд энэ боловсролыг хангалттай зааж чаддаггүй л байна.

**Биеийн тамирын багш бэлгийн амьдрал заасаар Л...**

Ийнхүү олон улсад шалгарсан арга болох бага наснаас нь нөхөн үржихүйн боловсрол олгох асуудалд манай төр хэрхэн анхаардаг билээ гэдэг асуулт ургаад гаргаад ирлээ. Тэгвэл энэ хүрээнд харин ч нэг “гажиг” шийдвэр гаргасан байдаг юм. Тодруулбал, өнгөрсөн Засгийн газрын үед буюу 2014 онд БШУ-ны сайдын тушаалаар

сургалтын хөтөлбөрөөс Эрүүл мэндийн хичээлийг хасчихсан. Үүнийгээ “Эрүүл мэндийн хичээлийг бусад хичээлтэй уялдуулах буюу биеийн тамир, биологийн хичээлээр орно” гэж тайлбарлаж байгаа. Энэ талаар БШПУСЯ-ны Суурь, бүрэн дунд боловсролын агуулга, стандарт, хөтөлбөр, үнэлгээний бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Ц.Чимэдлхам “Эрүүл мэндийн боловсролыг огт олгохгүй байгаа гэж ойлгож болохгүй. Энэ талын мэдлэг олгох арга, хэлбэр нь л өөрчлөгдсөн. Өмнөхөөс эрүүл мэндийн хичээлийн мэдлэг чадвар олгох цаг нь харин ч нэмэгдсэн. Хэд хэдэн хичээлийн агуулгад нэмж тусгагдсан. Тодруулбал, өмнө нь анги бүр долоо хоногт нэг цаг л эрүүл мэндийн хичээлийг ихэвчлэн хими, биологийн багш нар заадаг байсан. Харин одоо биеийн тамир, эрүүл мэнд гэж нэр нь өөрчлөгдөөд биеийн тамирын хичээлээр

эрүүл мэндийн хичээл орж байгаа. Түүнчлэн долоо хоног бүр ангиуд “Амьдрах чадварт сургах үйл ажиллагаа” гэдэг хичээлээр, хичээлээс гадуур үйл ажиллагаагаар долоо хоногт нэг цагаар эрүүл мэндтэй холбоотой үйл ажиллагаа явж байна. Биологийн хичээлээр эрүүл мэндийн холбогдолтой ихэнх агуулгыг зааж байгаа гээд дөрвөн хичээлээр сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгож байгаа. Харин сургуулиуд дээр эдгээр цагуудыг хэрхэн ашиглаж байгааг хэлж мэдэхгүй юм. Одоо хичээлийн шинэ жил эхлээд сарын хугацаа л өнгөрч байна. Гэхдээ шинэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт энэ асуудал тусгагдчихсан байгаа. Тиймээс эрүүл мэндийн хичээлийг дөрвөн хичээлтэй хавсран үзэх, хуучин шиг нь тусгайлан үзэх эсэхийг ярилцах болно. Үүнээс өмнө одоо эрүүл мэндийн боловсрол олгож байгаа хэлбэр нь болж байгаа эсэхийг үнэлэх үнэлгээний

ажил одоо төлөвлөгдөж байна. Тиймээс тун удахгүй одоогийн эрүүл мэндийн боловсрол олгох хэлбэр хэр оновчтой байгаа эсэхийг үнэлчихнэ гэсэн үг. Энэхүү хичээлийн асуудлаар төрийн бус байгууллагууд одоог хүртэл шаардлага ирүүлсээр байгаа. Тиймээс бид тун удахгүй эдгээр байгууллагуудтай уулзалт зохион байгуулахаар төлөвлөд байна” гэлээ. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгож, халдварт өвчний тархалтыг бууруулах, оюунтан, залуучуудад эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Тиймээс эрүүл мэндийн боловсрол олгох тогтолцоог “эрүүлжүүлэх” магадлалтай гэсэн үг. Хэдийгээр эрүүл мэндийн хичээлийг сургалтын хөтөлбөрөөс авч хаясан асуудлыг энэ мэтээр

эргэж харах гэж байгаа ч гэлээ нэлээд хугацаа зарцуулагдах нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл, төрийн бус байгууллагуудын хэлсэнчлэн Биеийн тамирын багш бэлгийн амьдралын асуудал, нөхөн үржихүйн амьдралыг сурагчдад заах аж. Уг нь энэхүү хичээлийг тусгайлан мэргэшсэн хүмүүс орох ёстой гэдэг нь ямар ч тэнэг хүнд ойлгомжтой баймаар.

**Бэлгийн замын өвчнөөр өвчлөгсдийн тал нь 15-24 насны залуучууд байна**

Монгол Улсын нийт хүн амын 40 орчим хувийг Монголын ирээдүй болсон 19-өөс доош насны залуус, өсвөр үеийнхэн эзэлдэг байна. Гэтэл тэдний дунд жирэмслэлт, бэлгийн замын халдварт өвчний өвчлөл өндөр хувьтай байгааг судалгаагаар тогтоожээ. Бүр дуу алдмаар тоо баримтыг Нийслэлийн эрүүл мэндийн хүрээлэнгээс зарлаад байна. Тодруулбал, 2015 онд нийт 80.434 эх амаржсаны 5.5 хувийг 20 хүртэлх насны эхчүүд эзэлсэн, Үр хөндөлт хийлгэсэн эмэгтэйчүүдийн 5.1 хувийг 20-иос доош, 70 хувийг 20-34 насныхан эзлэж байна. Түүнчлэн бэлгийн замаар дамжих халдвараар өвчлөгсдийн 43.4 хувь нь 15-24 насны залуучууд байгаа зэрэг сэтгэл түгшим мэдээлэл цацагдаад байна. Хөвгүүдийн хувьд бэлгийн замын ямар нэгэн өвчлөлийг хэн нэгэнд хэлэхээс санаа зовж явсаар хүндрүүлж эмнэлэгт ирж байгаа нь асуудал болоод байгааг эмч нар хэлж байна. Мэдээж шүү дээ. Биеийн тамирын багш бэлгэвч хэрхэн хэрэглэх талаар тэнд заахгүй нь ойлгомжтой. Хамгийн харамсалтай нь 16-19 насны охидын жирэмслэлт ихэвчлэн үр хөндөлтөөр төгсдөг гэдгийг мэргэжлийн хүмүүс хэлж буй. Тэгээд ч өсвөр насандаа жирэмсэлснээс болж олон мянган охид өөрийн сурч боловсрох, ирээдүйд сайн сайхан амьдрах боломжоо алдаж, түүнийгээ нуун дарагдуулах үүднээс хувийн эмнэлэгийн эмч гэх “хутга барьсан алуурчдад” ханддаг, улсын бүртгэлгүй буюу хорноотой үр зулбуулах эм худдан авдаг нь нууц асуудал биш. Учир нь энэ асуудлаас болж амиа алдаж байгаа охид олон байгаа. Ихэнхдээ энэ талын мэдээ мэдээлэл нууц байдлаар дарагддаг. Гэтэл хэдхэн халтар төгрөг олох гэж хүний үр хөнөөсөн этгээдүүдэд дэндүү хөнгөн ял оноодог тогтолцоотой байдаг нь харамсалтай. Тодруулбал, Хууль бусын эм зарж борлуулдаг иргэдэд хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээг дур мэдэн явуулсан гэсэн үндэслэлээр харууцлага тооцдог гээд асуудал олон байна. Энэ мэт өсвөр насны охид, хөвгүүдийн нөхөн үржихүйн болон эрүүл амьдралын боловсрол, зөв зан үйл, хандлагыг төлөвшүүлэх ажлын хүрээнд төрийн анхаарал буюу томчуудын оролцоо маш чухал байна. Хамгийн чухал нь өсвөр насныханд нөхөн үржихүйн эрүүл мэндийн чанартай, шуурхай үйлчилгээг цаг алдалгүй хүргэж, багаас нь зөв зан үйлийг төлөвшүүлэх нэн шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, нөхөн үржихүйн боловсролыг гэр бүл эцэг эх, нийгэм, сургуулийн орчинд жигд хандуулж чадаж гэмээгээ Монгол Улсын ирээдүй болсон хүүхэд, залуусын том асуудал болоод байгаа эрүүл мэндийн асуудлыг шийдэгдэж чадах нь байна.

# STRESS

Улаанбаатарт:

Маргааш  
 Өдөр 13  
 Шөнө 1

Нөгөөдөр  
 Өдөр 13  
 Шөнө 2

## Өдрийн зурхай

Намрын дунд улаагчин тахиа сарын Зургаан цагаан мөнгөтэй Харагчин үхэр өдөр. Буд гараг

Үс засуулбал: Хэрүүл тэмцэл ирнэ  
Наран ургах, шингэх: 06:56 - 18:45



Өдрийн өнгө: Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд зөв байх ба тогтой морь жилтнээ соргог муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналттай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус туулах, угаал үйлдэх, мал ариалжих, гэр бүрхэд сайн. Улааны үйлд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Н.БАТЗАЯА

Манай улсад сэтгүүлзүй гэх том салбар үүсч, хөгжөөд аль хэдийнэ 103 жилтэй золгожээ. Энэ хугацаанд Монголын сэтгүүлзүйн салбар хөгжин улам хүрээгээ тэлж, олон төрөлтэй болсон. Түүний нэг нь гэрэл зургийн сэтгүүлзүй. Сэтгүүлчийн бичиж буй мэдээ нийтлэлийн нэг томоохон шигтгээ, баримт нь гэрэл зураг гэдэг. Сайн гэрэл зураг муухан бичвэрийг авардаг ч гэх үг бий. Тэгвэл сэтгүүлзүйн томоохон төрөл зүйлийн нэг болох гэрэл зураг Монголын хэвлэл мэдээлэлд ч томоохон орон зайг эзэлсний илрэл нь “Өнөөдөр”-ийн гэрэл зурагчид” гэрэл зургийн үзэсгэлэн юм. Монголын хэвлэл мэдээллийн салбарт өөрийн орон зайг 20 жил тунхагласан тус



Гэрэл зурагчид Г.АРГУУЖИН

# “Өнөөдөр”-ийн хуудааснаа төлхөрсөн

## 20 ЖИМЙН БАРИМТЫГ ДЭЛГЭВ

сонин гэрэл зурагчдын үзэсгэлэн өчигдөр Монголын Үндэсний музейд нээгдэж, өнгөрсөн 20 жилийн түүхийг дэлгэлээ. Тэртээ 1996 оноос 2016 оныг хүртэлх үйл явдлын түүхэн агшин “Өнөөдөр” сонин гэрэл зурагчдын хальсанд бууж үлдсэн нь энэ аж.

Тухайлбал, тус үзэсгэлэнд АНУ-ын Төрийн бичгийн дарга Хиллари Клинтоны 2012 онд манай улсад хийсэн айлчлал, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн Бан Ги Мүны айлчлал, Ардчиллын эхэн үеийн Монголчуудын амьдрал гэх мэтчилэн түүхийн баримтыг үзүүлсэн байв. Энэхүү үзэсгэлэнд СГЗ Р.Чулуун, Н.Байгальмаа, С.Энхжаргал, Ж.Орхон, Б.Толка, Т.Чимгээ, Г.Эрдэнэтуяа, Ц.Батбаатар, П.Баттулга, Э.Харцага, Б.Бямба-Очир, Д.Эрдэнэцэг, Б.Мөнх-Эрдэнэ, Н.Амгаланбаатар зэрэг гэрэл зурагчдын нийт 70 бүтээл багтсан аж. Үзэсгэлэнгийн нээлтийн үеэр тэд “Бие биеэ нөхөж, нэг нэгнээсээ суралцаж,

залгамжлуулан “Өнөөдөр” сонин шиг гэрэл зурагтаа ач холбогдол өгдөг сонин, сайт үгүй. Тиймээс сайн уран бүтээл гарч, сургалтын онцгой нэгэн дөг бий болжээ” хэмээсэн юм. Энэ үеэр “Өнөөдөр” сонин үе үеийн гэрэл зурагчидтай уулзаж, ярилцлаа.

### Ц.БАТБААТАР: БИД МОНГОЛЫН ТҮҮХИЙГ ҮЕИЙН ҮЕД ӨРТӨӨЛӨН АВЧ ЯВАХ ҮЛС

/Монголын Гэрэл зурагчдын нээсэн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга/

“Би “Өнөөдөр” сонин гэрэл зургийн албанд 2004-2010 онд ажиллаж байх хугацаандаа үйл явдал болон улс төрийн зураг их авчээ. Аливаа үйл явдлын цөмд явж байдаг нь гэрэл зурагчдын онцлог. Бид Монголын түүхийг үеийн үед өртөөлөн авч явах улс. Зурагчин хүн өөрийн бүтээлээрээ бахархаж, тухайн он цагийг авч



үлддэгээрээ давуу талтай.

### Т.ЧИМГЭЭ: Ц.БАЛДОРЖ ЭРХЛЭГЧ БИДНИЙГ ӨГЛӨӨ БҮР ХУРЦАЛЖ ГАРГАДАГ БАЙСАН

/Өнөөдөр сонин гэрэл зурагчин/

“Би 1984 оноос гэрэл зураг авч байна. “Өнөөдөр” сонинд 1996-2009 онд ажиллаж, ихийг сурсан. Тэр үед хальсаар зураг авч цаасан дээр буулгадаг байсан бол одоо

техник технологи хөгжиж, цаг хугацаа хэмнэн маш амар болжээ. Гэрэл зургийг цаасаар авдаг үед гэрэл зураг чанартай байсан. “Өнөөдөр” сонин гэрэл зургийн албыг нийм хүчирхэг болгосон хүн бол Ц.Балдорж эрхлэгч. Биднийг өглөө бүр хурцалж гаргадаг байсан. Гэрэл зурагчин хүнд өөрийн өнцгөөс хардаг мэдрэмж маш чухал байдаг.

### Э.ХАРЦАГА: АЖЛАА ХИЙХ ХУГАЦААНДАА ГЭРЭЛ ЗУРГИЙН 19 УРАЛДААНД ОРОЛЦОЖ ТАЛД НЬ ТҮРҮҮЛСЭН

/Өнөөдөр сонин гэрэл зурагчин/

-Анх 1997 онд манай ангийнхан

сургуулийнхаа тухай сонин хийсэн. Тэгэхэд гэрэл зурагчнаар нь ажиллаж, түүнээс хойш гэрэл зураг дуртай болсон. Тэгээд сэтгүүлзүйн ангид элсэн орж, их сургууль төгсөөд одоог хүртэл “Өнөөдөр” сонин гэрэл зурагчнаар галаа манаад ажиллаж байна. Анх СГЗР.Чулуун даргатай, Т.Чимгээ архивын эрхлэгчтэй, Б.Толка, С.Энхжаргал гэдэг хоёр айхтар гэрэл зурагчинтай албанд орсон.

Тэднээс, энэ хамт олноос ихийг сурсан. Ажлаа хийх хугацаандаа гэрэл зургийн 19 уралдаанд оролцож, талд нь түрүүлжээ. Миний бүтээлүүдээс спорт 40 хувь, байгаль, экологи, нийгэм 40 хувь бусад салбар үлдсэн хувийг эзэлдэг.

### ДУУЛГАХ СОНИН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Загвар өмсөгч Э.Энхболдыг энэ сарын 8-12-ны хооронд Хонконгт болсон “International Fashion Super Model” тэмцээний эрэгтэй моделийн төрөлд шилдгийн шилдгээр шалгаран “Гранпри” шагналын эзэн болсон. Түүний энэхүү амжилтыг үнэлэн МЗХ-ны дэд Ерөнхийлөгч Ө.Шинэхүү хүлээн авч

## Загвар өмсөгч Э.Энхболд “ТЭРГҮҮНИЙ ЗАЛУУ” боллоо

уулзан, “Тэргүүний залуу” цол тэмдгээр шагнажээ. Энэ үеэр МЗХ-ны дэд Ерөнхийлөгч Ө.Шинэхүү “Энэ жил Монголын залуучуудын байгууллага үүсч хөгжсөний 95 жилийн ой, Монголын залуучуудын холбоо байгуулагдсаны 25 жилийн ой тохиож байна. Иймд салбар бүрийн тэргүүлэгч, салбартаа манлайлж амжилт гаргасан залуусыг хүлээн авч, тэдний амжилтыг үнэлэх, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулж байна” гэв. Харин загвар өмсөгч Э.Энхболдын хувьд “Хүн сайхан мөрөөдөлтэй байж, мөрөөдлийнхөө төлөө зогсолтгүй хөдөлмөрдөг, тэмүүлдэг байгаарай” хэмээн залуустаа уриалжээ. Дашрамд сонирхуулахад, тэрбээр энэхүү тэмцээний үеэр гадны уран бүтээлчдийн анхааралд өртөж, 2-3 киноны санал хүлээж авсан гэнэ.

### Бидэнд тохиолдсон



Мөнхбат.О

Манай нэг найз “Самарт явлаа, цөм хийнэ ээ” гээд л байсан юм. Би ч “За чи баригдав даа. Тэгээд самар ч үгүй, юу ч үгүй болоод ирвэ” гэсэн юм. Тэгсэн чинь найз маань саяхан “Дархандаа ирлээ дээ” гээд л фэйсбүүкдээ постолж байна. Би ч “За самар идье” гээд бичгэл “Юуны чинь самар. Долоо хоног баривчилгаанд яваад, ууланд төөрсөн хүн хайлгадаг юм даа” гэнэ ээ. Хаха

# 10

YEARS OF



## ЦААСААР Ч, ЦАХИМААР Ч УНШДАГ БОЛЛОО

Монголын үндэсний өдөр тутмын “Өглөөний сонин” 10 жилийнхээ ойн босгон дээр цаг үетэйгээ хөл нийлүүлэн, уншигч захиалагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцүүлэн, технологийн дэвшилийг ашиглан, ухаалаг утас, таблет дээр зориулсан аппкейшнтэй боллоо. Ингэснээр манай сонинг хэзээ ч, хаана ч гар утас, таблет ашиглан дэлхий даяар шууд унших боломжтой юм. Та гар утасныхаа Play store-ын хайх хэсэгт Өглөөний сонин, эсвэл Morningnews гэж бичээд хайлт хийнэ.

